

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН БАТАЛСАН ЗАХИРГААНЫ ХЭМ
ХЭМЖЭЭНИЙ АКТЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ЯВЦЫН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 5 дугаар сарын 12

Мандалговь хот

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хийж, захиргааны хэм хэмжээний актын үр дүнгийн талаар дээд байгууллага болон удирдлагуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт-шинжилгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалын дагуу хийж үнэлгээний дүнгийн явцыг гаргасан.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2019 оны А/393 дугаар захирамжаар батлагдсан “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох”, 2019 оны А/394 дугаар захирамжаар батлагдсан “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох”, Байгаль орчин аялал жуулчлалын сайд Аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/427, А/404 дугаар шийдвэрээр батлагдсан “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай” нийт 3 захирамжийн 36 заалтын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийхэд хэрэгжилтийн дундаж 94.2 хувьтай байна.

Явцын дүнг хүснэгтээр харуулбал:

Д/д	Шийдвэрийн нэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь				Хэрэгжилтийн дундаж хувь
			100	90	70	30	
1	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох тухай	12	8	4	-	-	96.6
2	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох	11	9	-	1	1	90.9
3	Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох	6	5	-	1	-	95.0
	Дүнгийн нэгтгэл	29	22	4	2	1	94.2

ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо		29
Бүрэн хэрэгжсэн	100	22
Хэрэгжих шатанд	90	4
	70	2
	30	1
Хэрэгжилтийн хувь		94.2

ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

1. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын хүрээнд:

2023 онд Төрийн аудитын газраас хог хаягдлын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хүрээнд аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах 2024 оны төлөвлөгөө гарч хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Сумдад Байгаль орчны хяналтын улсын байцаагч 5, мэргэжилтэн 3, хавсран гүйцэтгэж буй 5, мэргэжилтэн байхгүй 2 сум байна.

Аймгийн хэмжээнд Байгаль орчны хяналтын улсын байцаагч 6 ажиллаж байгаа бөгөөд аймаг сумын хэмжээнд хяналт тавьж ажиллаж шатахуун түгээх станцын 3 объект, төвлөрсөн халаалтын үйл ажиллагаа эрхлэгч 2 ААН-ын 11 объект, нийт 14 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн бөгөөд хог хаягдлын чиглэлээр илэрсэн 6 зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ц.ШИНХБАТ

ДУНГОВЬ АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.01.02

№	Анх хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь тусвиш	Хүрээ тусвиш	Хэрэгжийн Эх үүсвэр	Хугацаа	Хариуцах эзэн	Хангран ажиглах
1	2	3	4	5	6	7	8	9
Зорилт 1. Хог хаягдлын талаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хог хаягдлын менежментийг боловсруулж боловсруулах, зохион байгууллагуудад хяналт тавьж ажиллуулах.								
1.1	Хог хаягдлын хураамжийн хэмжээ, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тусгаарлах, буцлах, шидэглэн, нөмрө, тарифыг өргөмжлөн дагуу бодитой тогтоож амьсгалын багтаамж	Тариф багасган сувиан тоо	5	10	-	1-IV улирал	Сумын ИТХ, ЗДТГ	БОАЖГ
1.2	Хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлэх, хураамжийн орлогыг зарцуулалт дагуу бүрэн зарцуулах	Хог хаягдлын хураамжийн биеэцэглэлийн хувь	50%	65%	-	1-IV улирал	Сумын ЗДТГ	Татварын хэлтэс
1.3	Сумын төвлөрсөн хогийн шатны сандаргын хяналтын хянаж буй эхэнд, ямар ч шалгалт хийж, зөрчлийг арилгуулах зорилгоор албан шаардлага хүргүүлэх	Хяналт шалгалтын тоо	-	3	ОНТ 2.0	1-IV улирал	БОАЖГ, БОХУБ	Сумын ЗДТГ



Аймгийн хэмжээнд 322 хог ангилан ялгах савтай болсон байна.

Аймгийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж 2020-2023 онуудад нийт 243 тн дахивар нөөц цуглуулж Улаанбаатар хот дахь дахин боловсруулах үйлдвэрүүдэд тушаасан бол энэ оны эхний хагас жилээр 4тн 143,47 дахивар цуглуулж дахин боловсруулах үйлдвэрүүдэд тушаагаад байна.



2. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмын хүрээнд:

Сумдад нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдал төвлөрөхөөс урьдчилан сэргийлж бүх нийтийн их цэвэрлэгээг 9 удаа зохион байгуулж нийт 540 га талбайгаас 25 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.



3. Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмын хүрээнд:

Агаарын чанарын стандартад нийцсэн эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан болон хийн халаагч төхөөрөмжийг үе шаттай хэрэглээнд нэвтрүүлэх үүднээс НҮБ-ын Хүүхдийн Сан болон Монгол Улсын Засгийн Газрын хамтран хэрэгжүүлж буй “Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хөтөлбөр”-ийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП төслийн мэдээллийг нийтэд түгээж сурталчилж байна. Чип багц 2024 оны байдлаар 65 өрхөд олгогдсон.




Төвлөрсөн халаалтын зуухнуудад утаа шүүгч байршуулж улсын комисс хүлээж авсан.



Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого хийгдсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 4005 галлагаатай айл өрх тоологдсоноос Сайнцагаан суманд 1902, Сумдын хэмжээнд 2103 айл өрх тоологдсон байна. 2023 онтой харьцуулахад айл өрхийн тоо 70-р буурсан ба нийт нүүрсний хэрэглээ 313.1 тн-оор буурсан байна. 2023 онд усан халаалтын 15-100 кВт хүчин чадалтай 87 зуух, 100-4200 кВт хүчин чадалтай 25 зуух тоологдсоноос 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 15-100 квт хүчин ч адалтай зуух 84 болж буурсан байн



Аймаг, сумын нэр		Нийт айл өрх	Гэрийн зуухны тоо				Гэрийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ, тн/жил			Байшингийн зуухны		Байшингийн зууханд хэрэглэсэн түлшний		
			Ердийн	Сайжруу план	Нүүрс	Мод м³	саван руулсан түлш	Бусад	Ердийн	Сайжруу план	Нүүрс	Мод м³	саван руулсан түлш	Бусад
Аймгийн төвийн хэмжээнд	Дундговь аймаг Сайнцагаан сум	1902	1231	221	4616.62	1165		271.5	362	88	1532	349.2		3
Сумдын хэмжээнд		2103	1198	476	3193.1	85.3		2320.4	315	431	1985	74.8		1197.1
Сум тус бүрт	Говь-Угтаал	137	66	23	236.5			121	40	8	129			70
	Дэлэрцогот	146	61	37	155.5			254.5	21	27	106			101
	Өндөршил	117	67	0	168			148	38	12	123			105
	Адаацаг	151	89	2	181			218	40	20	140			95
	Далай	172	65	40	233	38.8		55.4	14	53	178.5	47.3		21.1
	Баянжаргал	144	66	25	208			82	27	26	123.5			46.5
	Дундговь аймгийн Сайнцагаан сум	341	6	185	489.5			402	8	142	370			344.5
	Луус	120	46	43	213			185.5	15	16	102			57.5
	Хулд	169	59	45	341	46.5		99	13	52	247	27.5		42
	Цагаандэлгэр	67	34	3	108.6			44	30	0	82.3			34
	Дэрсэн	141	102	7	180			177	20	12	60			61
	Дэлгэрхангай	215	90	49	331			296	21	55	223.5			159.5
Өлзийт	84	50	17	172			139	9	8	52			37	
Гурвансайхан	99	80		185			99	19		48			23	
Аймгийн хэмжээнд		4005	2429	697	7811.72	1250	0	2591.9	677	519	3517	424		1200.1

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй аймгийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний актуудын хэрэгжилтийн явцад жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийж холбогдох байгууллагуудад зөвлөмж өгч үр дүнг тооцон ажиллаж байна.

Дундговь аймагт хэрэгжиж буй 3 актын 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хийхэд 94,2 хувийн дундажтай хэрэгжиж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 4,8 хувиар өссөн байна.

Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох тухай актын 3 дугаар заалт өнгөрсөн онд хэрэгжилт гараагүй буюу 0 хувьтай байсан бол энэ хагас сарын байдлаар 100 биелэлтэй буюу Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2024 оны эхний 4 сарын байдлаар 46010.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 43555.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд хуванцар цуглуулах болон 3 төрлөөр ангилан ялгах, эмнэлгийн хог хаягдал ялгах зориулалт бүхий хогийн сав аймгийн хэмжээний нийт ангилан ялгах хогийн сав 311 байсан нь бол 2024 оны хагас жилийн байдлаар нийтийн эзэмшлийн талбайд 9, 2 ААН-д 2-р нэмэгдэж 322 болж өмнөх оноос 11 ангилан ялгах зориулалт бүхий хогийн саваар нэмэгдсэн байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн байдалд улирал бүр хяналт тавьж сумдаас болон бусад байгууллагаас зайлшгүй гарах судалгааг хагас бүтэн жилээр нэгтгэн гаргаж, тайланд тусгаж байх

Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилт удаашралтай болон тасарч болзошгүй заалтуудыг хяналтад авч, эрчимжүүлэх арга хэмжээг зохион байгуулан хэрэгжилт, үр дүнгийн талаар удирдлагуудыг мэдээллээр хангаж байх

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Б.СОЛОНГО

